

ХОРИН ХОЁРДУГААР БААЗ ХК ХУВЬЦААТ КОМПАНИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2024 оны 03 сарын 21 өдөр

Дугаар 24/02

Улаанбаатар хот

Г “Хорин хоёр дугаар бааз” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн

ээлжит хурлыг зарлан хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.4 дэх заалт, 60 дугаар зүйлийн 60.1 дахь заалтууд, Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 12 дугаар сарын 14-ны өдрийн 377 дугаар тоот тогтоолоор батлагдсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих” журмыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Компанийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны ээлжит хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 13.00 цагт Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 39 дугаар хороо Цагдаагийн академийн өргөн чөлөө гудамж, өөрийн байрны 101 тоотод хуралдуулахаар тогтоосугай.

1. Компанийн 2023 оны үйл ажиллагааны тайлангийн ТУЗ-ийн дүгнэлт
2. Компанийн 2023 оны санхүүгийн тайлангийн ТУЗ-ийн дүгнэлт
3. Санхүүгийн тайланд хийсэн Аудитын дүгнэлт.
4. Ногдол ашиг хуваарьлахгүй тухай ТУЗ-ийн гаргасан шийдвэрийг танилцуулах
5. Бусад

3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдрөөр тогтоосугай.

Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын тухай зарыг өдөр тутмын хэвлэл мэдээллийн хэрэгслээр 2024 оны 03 дугаар сарын 26-ны өдөр МХБ сайт болон өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр, 2024 оны 04 дүгээр сарын 10-ны өдөр дахин мэдээлэх, Монголын хөрөнгийн биржийн сайтад тавих, брокерын компанид хүргүүлэх зэргээр хувьцаа эзэмшигчдэд мэдэгдсүгэй.

5. Хурлын зар өгөхтэй холбоотой зардлыг хурал зохион байгуулах комиссын дарга /3. Туул /-д гаргаж өгөхийг компанийн санхүүд даалгасугай.

6. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь Хавсралт 1-д заасан бичиг баримтыг БДК-иудаас авч танилцах эрхтэй болохыг дурдсугай.

7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс энэхүү хурлаар хэлэлцэх асуудлаар саналын хуудсаар санал авах “саналын хуудас”-ны агуулгыг хавсралт 2-д зааснаар баталсугай.

8. Компанийн ээлжит хурлаар хэлэлцүүлэх асуудлаар санал авах хуудсыг хүлээн авах эцсийн хугацааг 2024 оны 04 сарын 10-ны өдрийн 14 цагаар тасалбар болгосугай.

9. Компанийн ээлжит хурал удирдах даргаар ТУЗ дарга /Л.Гүндэгмаа/-г зохион байгуулах комиссын даргаар /З.Туул/-ыг тооллогын комиссын даргаар /Т.Халиун/-ыг гишүүнээр /Б.Есөн-Эрдэнэ/-г тус тус томилсугай.

10. Хурлаар хэлэлцүүлэх асуудалтай холбоотой танилцуулга, хурлаас гарах шийдвэрийн төслийг тогтоосон хугацаанд бэлэн болгож, хувьцаа эзэмшигчдийн хурлыг зохион байгуулахыг хурал зохион байгуулах комисст даалгасугай. .

11. Хурал хуралдуулах тухай тогтоолыг гаргаснаас хойш 3 хоногийн дотор “22-р бааз” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл”-ийг Хавсралт 3-д заасан маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, Хөрөнгийн биржид хүргэхийг хурал зохион байгуулах комиссын дарга /З.Туул /-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ

ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Л.ГҮНДЭГМАА /